


Ипотекийн зээлийн тайлан

2013 оны 4 дүгээр сар

Ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 4.5 хувь буюу 41 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 34 хувь буюу 239.8 тэрбум төгрөгөөр өсч 944.5 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант сард банкууд нийт 1435 зээлдэгчид 58.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 31412 хүрчээ.

Ипотекийн зээлийн жилийн өсөлт 2013 оны эхний саруудын турш харьцангуй тогтвортой байв. Ипотекийн зээлийн жилийн өсөлтийн хурд өнгөрсөн оны мөн үеэс 38.6 нэгж хувиар саарчээ.



Тайлант сард банкууд 58.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосон нь өмнөх сарынхаас 30.4 хувь буюу 13.6 тэрбум төгрөгөөр илүү байв.



Тайлант сард банкуудын олгосон зээлийн 96.1 хувь нь төгрөгийн зээл, 3.9 хувь нь гадаад валютын зээл байв.

2013 оны 4 дүгээр сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 6.2 хувийг гадаад валютын зээл, 93.8 хувийг төгрөгийн зээл бүрдүүлжээ.

Тайлант сард олгосон зээлийн дийлэнх буюу 77.7 хувийг шинээр ашиглалтанд орж буй орон сууц худалдан авахад олгожээ.




Тухайн сарын нэг зээлдэгчид ногдох ипотекийн зээлийн үлдэгдэл тогтвортой өсч байгаа бөгөөд 2013 оны 4 дүгээр сарын байдлаар нэг зээлдэгчид 40.7 сая төгрөг ногдож байв.




Нийт ипотекийн зээлийн чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хувь харьцангуй тогтвортой байна. Тайлант сарын байдлаар чанаргүй зээлийн хувь 0.6 хувь, хугацаа хэтэрсэн зээлийнх 0.5 хувьтай байв.

2013 оны 4 дүгээр сарын байдлаар нийт 31412 зээлдэгч ипотекийн зээлтэй байна. Тайлант сард нийт 1472 иргэд ипотекийн зээл авах хүсэлт гаргаж 1435 иргэд зээлд хамрагджээ. Үүнээс 198 зээлдэгч нь ЗГ-ын хөтөлбөрийн зээлд хамрагдсан бол 1237 зээлдэгчдэд банк өөрийн эх үүсвэрээс зээл олгосон байна.



Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа нь 13 жил байв. Тайлант сард банкууд 1-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 12.7 жил байв.

Ипотекийн зээл, хугацааны ангиллаар



Тухайн сард олгосон ипотекийн зээлийн 48.9 хувийг нь 15 жил, 27.4 хувийг нь 10 жил, 8.3 хувийг нь 5 жил, 8.2 хувийг нь 20 жил хугацаатай олгосон бол нийт ипотекийн зээлийн 51 хувийг нь 15 жил, 28 хувийг нь 10 жил, 7.7 хувийг нь 20 жил, 4.8 хувийг нь 5 жилийн хугацаатай олгосон байна.

Банкуудын 2013 оны 4 дүгээр сард олгосон ипотекийн зээлийн хамгийн өндөр хүү нь жилийн 30 хувь, хамгийн бага нь жилийн 6.0 хувьтай ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хүү байсан бөгөөд нийт системийн жигнэсэн дундаж хүү нь 15.8 хувьтай гарсан байна. Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү нь 17.5 хувь байсан бол валютын зээлийн жигнэсэн дундаж хүү нь 13.9 хувь байв.